

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛЖ БАЙГАА СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Сонгуулийн сурталчилгааны 2 дахь долоо хоног

Тайлангийн хамрах хугацаа: **2024.06.17-06.23**

2024.06.26-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22-т заасан чиг үүргийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт **119 телевиз, Улаанбаатар хотын 31 радиогийн хөтөлбөрт** хуульд заасан үзүүлэлтээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийж байна. Сонгуулийн сурталчилгааны эхний 7 хоногт радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн тайлан мэдээг 2024 оны 6-р сарын 19-ний өдөр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн.

Радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны 2 дахь долоо хоногийн буюу 2024 оны 6-р сарын 17-23-ны өдрүүдийн хяналтын тайлан мэдээг үүгээр танилцуулж байна.

Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны эхний 14 хоногийн байдлаар нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ хуулиар тогтоосон нэг хоногт нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны 60 минут, нам, эвсэл нэр дэвшигчийн сурталчилгааг 1 хоногт 15 минутаас хэтрүүлэхгүй байх, нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх зэрэг хуулиар тогтоосон журмыг баримтлан хууль тогтоомжийг дээдлэн ажиллаж байна.

1. Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш 2024.06.10-06.23-ны өдрүүдэд радио, телевизүүдээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байдал:

Хүснэгт 1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн телевизийн тоо

Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрлийн тоо/Хяналтад тоо	Сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизүүд	Сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевиз								
			Эхний 7 хоног (06.10-16)	06.17	06.18	06.19	06.20	06.21	06.22	06.23	Нийт
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18/18	17	17	17	17	17	17	16	17	17	17
Арилжааны телевиз	53/50	24	21	16	14	13	16	18	14	15	18
Орон нутгийн телевиз	48/41 ¹	42	28	25	26	28	26	23	26	26	32

¹ Хардаар 4 ТВ-н бичлэг ирж хянагдаж байгаа, 1 ТВ-н (тэнгэр тв орхон) эфир техникийн шалтгаанаар тог зогссон. 6 ТВ сурталчилгаа нэвтрүүлэхгүй үйл ажиллагаагаа зогсоосон.

Радио -УБ	31/31	24	18	19	18	17	17	16	18	16	19
Радио - Орон нутаг	25/24	18	Бичлэгээр								
	175*	125	84	Нийт сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тоо 67 ТВ, 19 радио							86

*МҮОНРТ-ийн телевизийн 5 суваг, радиогийн 4 суваг дээрх тоонд ороогүй хэдий ч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үзүүлэлтээр мөн хяналт тавьж байна.

Сонгуулийн сурталчилгааны 2 дахь 7 хоногт бүртгүүлсэн эрх бүхий **83** телевиз, **24** радиогоос нийт **67** телевиз, **19** радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн бөгөөд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн эрх бүхий **16** телевиз, **5** радио сурталчилгаа нэвтрүүлээгүй байна.

Орон нутгийн радиогийн хувьд: Орон нутагт сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй 18 радио, сурталчилгаа нэвтрүүлэхгүй 1 радио нийт 19 радиогоос 2024 оны 06-р сарын 10-16-ны өдрүүдийн эфирийн бичлэг хуулсан DVD-г хүлээн авсан ба 06-р сарын 17-21-ний өдрийн бичлэгийг хүлээн авч байна.

2. Сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио, телевизээр сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх:

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т “Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэхийг хориглоно” гэж заасан ба сурталчилгааны 2 дахь долоо хоногийн хугацаанд сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн тохиолдол бүртгэгдээгүй болно.


3. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тухайд:

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **67** телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах **318:40:43** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **15:30:47** цагийн сурталчилгааны шторк, нийт **334:11:30** цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 2. Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг

№	Он сар өдөр	ТВ-ийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	17:28:04	0:02:29	17:30:33
		8 Орон нутгийн ТВ	1:18:52	0:32:31	1:51:23
2	2024.06.11	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	15:11:51	0:02:51	15:14:42
		17 Орон нутгийн ТВ	3:16:14	0:43:05	3:59:19
3	2024.06.12	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:47:58	0:06:35	15:54:33
		22 Орон нутгийн ТВ	5:09:47	0:37:56	5:47:43
4	2024.06.13	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	16:15:17	0:10:24	16:25:41

		18 Орон нутгийн ТВ	4:20:36	0:37:51	4:58:27
5	2024.06.14	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	9:02:27	0:10:01	9:12:28
		23 Орон нутгийн ТВ	5:39:11	0:38:59	6:18:10
6	2024.06.15	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	12:13:44	0:09:57	12:23:41
		22 Орон нутгийн ТВ	5:42:32	0:44:08	6:26:40
7	2024.06.16	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	21:52:02	0:07:50	21:59:52
		22 Орон нутгийн ТВ	5:05:25	0:35:26	5:40:51
8	2024.06.17	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	16:23:11	0:13:54	16:37:05
		25 Орон нутгийн ТВ	7:53:31	1:03:21	8:56:52
9	2024.06.18	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:46:11	0:11:52	15:58:03
		26 Орон нутгийн ТВ	7:59:33	0:49:39	8:49:12
10	2024.06.19	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:47:44	0:10:01	15:57:45
		27 Орон нутгийн ТВ	8:36:37	0:55:58	9:32:35
11	2024.06.20	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	18:06:19	0:06:01	18:12:20
		26 Орон нутгийн ТВ	8:04:16	1:23:10	9:27:26
12	2024.06.21	34 (17 ӨНТВ, 16 АрТВ)	22:11:21	0:08:25	22:19:46
		23 Орон нутгийн ТВ	6:42:07	1:08:22	7:50:29
13	2024.06.22	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	18:08:21	0:20:36	18:28:57
		26 Орон нутгийн ТВ	8:02:34	1:39:38	9:42:12
14	2024.06.23	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	18:42:19	0:15:52	18:58:11
		26 Орон нутгийн ТВ	7:52:39	1:43:55	9:36:34
Нийт 1-р 7 хоногт			138:24:00	5:20:03	143:44:03
Нийт 2-р 7 хоногт			318:40:43	15:30:47	334:11:30



Телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааг төрлөөр нь авч үзэхэд 95.35 хувийг сурталчилгааны нэвтрүүлэг, 46.65 хувийг реклам тус тус эзэлж байна.

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **19** радиогоор нам, эвсэл, нэр дэвшигчдийн **8:14:30** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **54:48:39** цагийн

сурталчилгааны шторк, нийт **63:03:09** цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 3. **Радиоогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг**

№	Сурталчилгаа нэвтрүүлсэн өдөр	Радиоогийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	7	2:08:15	0:03:02	2:11:17
2	2024.06.11	7	0:00:00	1:59:16	1:59:16
3	2024.06.12	8	0:00:00	3:10:51	3:10:51
4	2024.06.13	7	0:54:54	2:15:56	3:10:50
5	2024.06.14	8	0:00:00	3:07:54	3:07:54
6	2024.06.15	13	0:51:03	4:04:18	4:55:21
7	2024.06.16	18	0:44:50	5:56:50	6:41:40
8	2024.06.17	19	0:48:15	4:51:01	5:39:16
9	2024.06.18	18	0:45:49	5:06:41	5:52:30
10	2024.06.19	17	0:30:38	5:11:48	5:42:26
11	2024.06.20	17	0:42:38	4:46:08	5:28:46
12	2024.06.21	16	0:11:46	4:49:31	5:01:17
13	2024.06.22	17	0:18:15	4:54:12	5:12:27
14	2024.06.23	16	0:18:07	4:31:11	4:49:18
Нийт (1-р 7 хоногт)			4:39:02	20:38:07	25:17:09
Нийт (2-р 7 хоногт)			8:14:30	54:48:39	63:03:09



Улаанбаатар хотын радиоогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны **13.07** хувийг нэвтрүүлэг, **86.92** хувийг сурталчилгааны реклам (шторк) тус тус эзэлсэн байна.

4. Радио, телевизүүдийн хөтөлбөрт хуульд заасан зөрчил бүртгэгдсэн эсэх:

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингд хамрагдсан хугацаа: 2024.06.17-2024.06.21

Хүснэгт 4. Сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүн

№	Хяналт тавьсан үзүүлэлт	Сурталчилгааны эхний 7 хоног (06.10-06.23)	Улаанбаатар				Орон нутаг
			06 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд				
			ӨН Телевиз	Ар Телевиз	Радио	Телевиз	
1	Эх сурвалжийг дурдаагүй сонгуулийн сурталчилгаа (Хуулийн 39.4)	-	-	-	-	2 ТВ	
2	Сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/- аас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.6)	-	-	-	-	-	
3	Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааны хугацаа хоногт 15 минутаас хэтэрсэн эсэх: (Хуулийн 46.7)	3 ТВ (Арилжаа-2, Орон нутгийн 1)	-	1 ТВ	-	3 ТВ	
4	Мэдээ: Нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.14)	4ТВ (Арилжаа-3, Орон нутгийн 1)	-	-	-	1 ТВ	
5	Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зааснаас бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн эсэх (Хуулийн 48.10)	21ТВ (Арилжаа-14 Орон нутгийн 7) ФМ16	1 ТВ	6 ТВ	9 (Дуу)	4 ТВ	
6	Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх. (Хуулийн 46.28)	-	-	-	-	-	

Хуулийн үзүүлэлт тус бүрээр гаргасан хяналт, мониторингийн дүн мэдээ

1. Нэгдсэн дүнгээр: МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны 2 дахь 7 хоногийн хяналт, мониторингийн дүн, мэдээгээр радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.6 (Сурталчилгааг хоногт **1 цаг /60 минут/-**аас хэтрүүлсэн эсэх), 46.28 (Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх) заалтын ямар нэгэн зөрчил гаргаагүй байна.

2. Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичээгүй, эх сурвалжийг дурдаагүй сурталчилгааны нэвтрүүлэг гаргасан зөрчил орон нутгийн 2 телевизэд бүртгэгдсэн

Хүснэгт 5. Сурталчилгааны эх сурвалж дурдаагүй буюу сурталчилгааны хугацаанд захиалагч нам, эвсэл, нэр дэвшигчийг тодорхой гаргаагүй сурталчилгаа бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ТВ тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	06-р сарын 23-ны өдөр	Орон нутгийн 2 ТВ	Дорнод-Мижи ТВ, Налайх- Буян ТВ	Иргэний зориг ногоон намын Хэнийг дугуйлах вэ? сурталчилгааны нэвтрүүлэг, МАН-ын Ачаа тэнцүүлсэн алба, Монгол Улсын Засгийн газрын ажил тоон хэлээр сурталчилгааны нэвтрүүлэг Аль нам, эвслийн сонгуулийн сурталчилгаа гэдэг нь тодорхой, ойлгомжтой байсан тул сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах 15 минутад оруулж тооцоход хуульд заасан хугацаа хэтрээгүй. Тухайн 2 телевизэд захиалагч нам, эвслийн нэрийг нэвтрүүлгийн туршид байршуулах талаар анхааруулсан.

3. [Хоногт гарах нэг, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид ногдох 15 минут хэтрүүлсэн эсэх мэдээлэл:](#)

Хүснэгт 6. Сурталчилгааны 15 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ТВ тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	06-р сарын 19-ний өдөр	Орон нутгийн 1 ТВ	Дархан-Уул ТВ4	Тус телевизийн хувьд нэвтрүүлгийн давталт гарсан.
2	06-р сарын 22-ны өдөр	3 ТВ,	Ховд- Жаргалант, Ховд ТВ, УБ-Мянгат малчин ТВ	Сурталчилгааны шторкуудыг давталттай гаргасан нь хэтрэлт болсон.
3	06-р сарын 23-ны өдөр	Орон нутгийн 1 ТВ	Ховд- Жаргалант	Сурталчилгааны шторкуудыг давталттай гаргасан нь хэтрэлт болсон.
№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ФМ радио тоо	Хэтрэлт бүртгэгдсэн ФМ Радио	Тайлбар
1	06-р сарын 19 ны өдөр	2 радио	ФМ 101.7, 104.5	ФМ101.7 МАН-ын, ФМ 104.5 ИХ намын сурталчилгааны хугацааг хэтрүүлсэн.
2	06-р сарын 20-ны өдөр	3 радио	ФМ 101.7, ФМ107.5, ФМ 96.3,	Нэг нам, эвслийн сурталчилгааг хоногт 15 минутаас хэтрүүлсэн. Тус бүр нэг нэг удаа.
3	06-р сарын 21-22 ны өдөр	2 радио	ФМ96.3, ФМ 107.5	Нэг нам, эвслийн сурталчилгааг хоногт 15 минутаас хэтрүүлсэн. Тус бүр нэг нэг удаа.
4	06-р сарын 23 ны өдөр	1 радио	ФМ96.3	Нэг нам, эвслийн сурталчилгааг хоногт 15 минутаас хэтрүүлсэн. ФМ96.3

Хийморь ТВ ХХК-ийн ТВ4 телевиз, Эхлэх шинэ жаргалант ХХК-ийн Жаргалант телевиз, Агрегатор ХХК-ийн Тэргүүлэгч ФМ101.7, Авто радио ерэн зургаа аравны гурав ХМХ-ийн авто радио ФМ96.3 радиогийн бүртгэгдсэн 15 минутын хэтрэлтийг хуулийн 46.24-т заасны дагуу мэдэгдэж, сануулах арга хэмжээ авч ажиллалаа.

4. [Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх:](#)

Хүснэгт 7. Мэдээний 5 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал.

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн радио, телевиз	Тайлбар м
1	06-р сарын 17, 21-ний өдөр	Орон нутгийн 1 ТВ	Дархан-Уул ТВ4	1 мин 14мин
2	Бусад өдөр	Хэтрэлт бүртгэгдээгүй	-	-

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн хувьд хэтрэлт бүртгэгдээгүй.

- **Жич:** Нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ хоногт 5 минутаас хэтрэхгүй байх хуулийн 46.14 дахь заалтын тухайд: Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.19-т заасны дагуу хуулийн 46.14 дэх заалттай холбоотой гомдол, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу холбогдох баримт мэдээллийг хянан үзнэ гэж заасан.

Иймд тус хорооны хяналт, мониторингд мэдээний 5 минут хэтрүүлсэн гэж бүртгэгдсэн тохиолдолд радио, телевизүүдэд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх үүднээс тухайн радио, телевизэд мэдэгдэж, зөвлөж, анхааруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

5. [Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон сурталчилгааны бус нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлага нэвтрүүлсэн эсэх:](#)

- Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглосон. (Хуулийн 48.10)

- 5.1. [Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгээр бүртгэгдсэн.](#)

Хүснэгт 8. Телевизүүдээр нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгийн бүртгэл

№	Бүртгэгдсэн тоо	Нэвтрүүлэг бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	УБ ӨНТВ 1 ТВ	ТМ телевиз	Шинжлэх ухааны нийтлэл, нэр дэвшигч Норовын Тэгшбаярын оролцсон нэвтрүүлэг
2	УБ арилжааны 6 ТВ	Бидний цөөхөн Монголчууд, Суваг-1, Хөгжил ТВ, Channel-11, ТВ2, Гандан,	Хүнсний хувьсгал нэвтрүүлгээс гадна Ахмадуудын цаг, Монгол музейн товчоон, Зөрлөг УСКино, Chinguns kids podcast, Хөх сувд мөсний баяр 2023, Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал" нэвтрүүлэгт нэр дэвшигчдийн дүрс, яриа орсон. Нэр дэвшигч С.Жавхлангийн дуулсан "Төрийн дуулал"
3	Орон нутгийн 4 ТВ	Дархан-Уул - ТВ4, DBS, Орхон-EBS, Хөвсгөл-Хөвсгөл	Хөх сувд мөсний баяр 2023, Шинжлэх ухааны нийтлэл, нэр дэвшигч Норовын Тэгшбаярын оролцсон нэвтрүүлэг, Ч.Лодойсамбуугийн Энэрэлтэй хамтран дуулсан Tonight's Sky дуу, EBS- Шинэ танил, нэвтрүүлэг, Урлаг уран сайхны үзүүлбэрт С.Жавхлан гишүүн дуулсан. Тухайн нэр дэвшигчийн тойрогт хөтөлбөр нь дамждаггүй ТВ хэдий ч анхааруулсан.

Дээрх нэр дэвшигчийн дүрс бичлэг, яриа орсон сурталчилгааны бус нэвтрүүлэг бүртгэгдсэн тохиолдолд эхний удаа утсаар анхааруулан зөвлөгөө өгч ажилласан бол зөрчил давтагдсан зарим үйлчилгээ эрхлэгчдэд Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.24-т (Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх талаар энэ хуулийн 46.20-д заасан журам зөрчсөн бол эхний удаад сануулах арга хэмжээ авах, эсхүл радио, телевизийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг санал авах өдөр хүртэл цуцлах тухай шийдвэр гаргана) заасны дагуу **5 ТВ**-д сануулах арга хэмжээг авч албан бичиг хүргүүлсэн.

Үүнд: Жи суваг ХХК-ийн **Гандан ТВ**, Энтертайнмент энтерпрейс ХХК-ийн **Бидний цөөхөн монголчууд ТВ**, Маст технологи ХХК-ийн **News channel ТВ**, Хөгжил телевиз ХХК-ийн **Хөгжил ТВ**, Хийморь ТВ ХХК-ийн **ТВ4** телевизүүдэд сануулах арга хэмжээ авсан албан бичиг хүргүүлсэн байна.

6. Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх

- Сонгуулийн сурталчилгааны эхний болон 2 дахь 7 хоногт хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн зөрчил бүртгэгдээгүй.

Улаанбаатар хотын радиогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн

Радиоогоор нэвтрүүлсэн нэр дэвшигчийн дуу нэвтрүүлсэн бүртгэл

Хүснэгт 9. Радиоогоор нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн бүртгэл

Огноо	Дуу бүртгэгдсэн тоо	Зөрчил бүртгэгдсэн радио, телевиз	Зөрчлийн агуулга
06-р сарын 17	5	ФМ 104.5, ФМ92.1, ФМ96.9, ФМ97.5, ФМ99.7	С.Жавхлан, Д.Баясгалан дуу
06-р сарын 18	3	ФМ101.7, ФМ92.1 ФМ97.5	С.Жавхлан, Д.Баясгалан, Ш.Бат-Эрдэнэ дуу
06-р сарын 19	3	ФМ99.3, ФМ96.9, ФМ99.7	С.Жавхлан
06-р сарын 20	3	ФМ 92.1, ФМ 96.9, ФМ 99.7	Д.Баясгалан, Х.Батмэнд, С.Жавхлан
06-р сарын 21	5	ФМ 92.1, ФМ 96.9, ФМ 99.8, ФМ 99.7 ФМ99.3	Д.Баясгалан, Ш. Бат-Эрдэнэ, С.Жавхлан
06-р сарын 22	4	ФМ 101.7, ФМ 92.1, ФМ102.1, ФМ 99.3	С.Жавхлан, Ш.Бат-Эрдэнэ
06-р сарын 23	4	ФМ 92.1, ФМ102.1, ФМ 96.3, ФМ89.7	С.Жавхлан, Ш.Бат-Эрдэнэ М.Нарантуяа НАРА

Сурталчилгааны эхний 7 хоногт дээрх 11 радиогийн хувьд нэр дэвшигчдийн дуу нэвтрүүлсэн. Нэр дэвшигчдийн нэр дэвшсэн тойргуудад хөтөлбөр нь цацагддаггүй тул утсаар анхааруулж, зөвлөмж өгч ажиллав.

МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Сонгуулийн сурталчилгааны 2 дахь 7 хоног

Хамрах хугацаа 6 сарын 17-23-ны өдрүүд

МҮОНТ-ийн мэтгэлцээний нэгдсэн тайлан

МҮОНТ 6-р сарын 17-23 -ны өдрүүд

Огноо	Мэтгэлцээний нэвтрүүлгийн тоо	Нийт цаг	Хуваарийн дагуу нэвтрүүлсэн эсэх
06-р сарын 10-16	23	34 цаг 30 минутын мэтгэлцээн	Бүх мэтгэлцээн батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн
06-р сарын 17-23	21	26 цаг 58 минутын мэтгэлцээн	Бүх мэтгэлцээн батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн
	44	61 цаг 28 минут	Бүх мэтгэлцээн батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн

МҮОНТ-ийн MNB сувгаар 6-р сарын 10-23-ны өдрүүдэд 44 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлэх хуваарь, цаг төлөвлөсөн нь бүгд хуваарийн дагуу нэвтрүүлсэн байна. Мэтгэлцээнд 18 нам, 2 эвслийн 129 нэр дэвшигч (давхардсан тоогоор) оролцсон бол 4 бие даан нэр дэвшигч мэтгэлцжээ.

Харин хуваарилагдсан өдөр, цагтаа Иргэний хөдөлгөөний нам 4 удаа, Монголын либерал ардчилсан нам 4 удаа, Эх орончдын нэгдсэн нам 5 удаа, Иргэдийн оролцооны нам 1 удаа, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн эвсэл 1, Үндэсний эвсэл 2 удаа, Үнэн ба зөв нам 1 удаа төлөөлөл оролцуулаагүй бол 17 бие даан нэр дэвшигч мэтгэлцээнд оролцоогүй байна.

Монголын мэдээ сувгаар мэтгэлцээний нэвтрүүлгүүдийг давтан нэвтрүүлж байна.

МҮОНТ-ээс бусад телевизээр мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн тухай:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд зөвхөн МҮОНРТ бус бусад телевизүүдээр сонгогчдын мэдэх эрхийг хангах үүднээс мэтгэлцээн нэвтрүүлж байгаа нь сайшаалтай байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.17-д Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй бөгөөд уг нэвтрүүлэгт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байх шаардлага тавьсан.

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.11-т заасны дагуу улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлэхдээ мэтгэлцээний тогтсон дэгтэй байх, оролцогчдын нэрсийг тэдгээрийн нэр дэвшүүлсэн нэрийг, нам, эвслийн нэрийн хамт тодорхой илэрхийлэх талаар заасан.

Иймд телевизүүдээр нэвтрүүлсэн мэтгэлцээний нэвтрүүлэг нь дээрх хууль, журамд нийцсэн эсэхийг хянаж, тайлан мэдээ гаргалаа.

№	Огноо	Сурталчилгааны эхний 7 хоногт (06.10-06.23)	Мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн телевизийн тоо	Нийт мэтгэлцээний нэвтрүүлгийн тоо (давталтын дугаар орсон)	Мэтгэлцээн нэвтрүүлсэн телевизийн нэрс
1	06-р сарын 17	4 ТВ –р 28 удаагийн мэтгэлцээн	3 тв	6	TenGer, ТВ8, Соён гэгээрүүлэгч
2	06-р сарын 18		3 тв	6	TenGer ТВ8, Соён гэгээрүүлэгч
3	06-р сарын 19		4 тв	7	TenGer, ТВ8, Соён гэгээрүүлэгч, ТВ9
4	06-р сарын 20		3 тв	5	TenGer, ТВ8, Соён гэгээрүүлэгч
5	06-р сарын 21		3 тв	5	TenGer, ТВ8, Соён гэгээрүүлэгч
6	06-р сарын 22		3 тв	6	TenGer , ТВ8, Соён гэгээрүүлэгч
7	06-р сарын 23		3 тв	6	TenGer , ТВ8, Соён гэгээрүүлэгч
	Нийт	4ТВ	3ТВ	41 мэтгэлцээний нэвтрүүлэг	
		4ТВ		69 мэтгэлцээн	

Мониторингоор 6-р сарын 17-23-ны өдрүүдэд TenGer, Соён гэгээрүүлэгч, ТВ8, ТВ9 телевизүүдээр 41 удаагийн нийт 61 цаг 40 минутын мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлсэн

байна. TenGer, ТВ8 телевизүүд мэтгэлцээний нэвтрүүлгээ бүрэн дохионы хэлтэй нэвтрүүлсэн нь 48 цаг 10 минутын нэвтрүүлэг байна.

Эдгээрийн 4 телевизээр нэвтрүүлсэн мэтгэлцээний нэвтрүүлгийн 19 дугаар буюу 27 цаг 40 минутын нэвтрүүлэг нь шинээр бэлтгэн нэвтрүүлсэн дугаар байгаа бол бусад 22 дугаарын 21 цагийн нэвтрүүлэг нь давталтын дугаарууд байна. Соён гэгээрүүлэгч болон ТВ9 телевизийн мэтгэлцээний нэвтрүүлэг нь 4 оролцогчтой, TenGer телевизийн мэтгэлцээний нэвтрүүлэг нь 6 оролцогчтой байгаа бол ТВ8 телевизийн мэтгэлцээний нэвтрүүлгүүдэд 2-4 оролцогч оролцсон байна. Эдгээр телевизүүд нь нэвтрүүлэгтээ өөр, өөр нам, эвсэл түүнчлэн бие даан нэр дэвшигч оролцуулж байгаа нь оролцогчдын төлөөллийн тэгш байдлыг хангаж байна гэж үзэж байна.

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ, СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Сонгуулийн сурталчилгааны 2 дахь 7 хоногийн тайлан

Радио, телевиз нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.15-т заасны дагуу сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос радио, телевизүүдээр нэвтрүүлсэн сонгогчдын боловсролын нэвтрүүлэг, сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл, сурталчилгаа хэрхэн нэвтрүүлж байгаа талаар хяналт, мониторинг хийж, тайлан мэдээг гаргаж байна.

Сурталчилгааны 2 дахь 7 хоногт

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эхний долоо хоног буюу 6-р сарын 10-16-ны өдрүүдэд 7 телевиз нийт 18 цаг 51 минутын Сонгогчдын боловсролд зориулсан бие даасан нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн 2 дахь долоо хоног буюу 6 сарын 17-23-ны өдрүүдэд MNB, MNB Монголын мэдээ, ТВ9, Тэнгэр ТВ, UBS, Ийгл ньус, ЕТВ, Баянхонгор – Номгон, Увс – МВС, Ховд - Олон ястан, Ховд зэрэг телевизүүдээр нийт **177** удаагийн **29:35:21** цагийн Сонгогчдын боловсролд **зориулсан бие даасан нэвтрүүлэг** бэлтгэн нэвтрүүлсэн байна.

Эдгээрийн **103** удаагийн **09:42:37** нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн нь олон нийтийн телевизийн MNB болон Монголын мэдээ сувгуудаар гарчээ.

Сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний сурталчилгаа

Телевизүүд сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл сурталчилгааг бүх телевизүүд идэвхтэй нэвтрүүлж байна. Тухайлбал, сонгуулийн сурталчилгааны эхний 7 хоногт 61 телевизээр нийт 3016 удаа 76 цагийн сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний шторк нэвтрүүлсэн бол сонгуулийн сурталчилгааны 2 дахь 7 хоногт сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл, сурталчилгааг 71 телевизээр нийт 4999 удаа 122:01:30 цаг нэвтрүүлсэн байна. Эдгээр богино хэмжээний мэдээлэл, сурталчилгааны 4416 удаагийн 108:10:44 цагийнх нь дохионы хэлний орчуулгатай, 2075 удаагийн 52:45:20 цагийнх нь бичгэн тайлбартай байсан байна.